



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 4/86

Бөхт

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 105 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх “Халаалтын шугамын өргөтгөл хийх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга Б.Амгаланжаргал (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд Д.Номин-Эрдэнэ (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

Б.Нарандэлгэр (Газрын даамал)

Ө.Бямбажаргал (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга О.Амгалантөр (Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

2. Хууль тогтоомжид заасны дагуу баримт бичгийг бүрдүүлэн, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Б.Амгаланжаргал)-д, архивын нэгж үүсгэн баримтжуулж ажиллахыг нарийн бичгийн дарга (О.Амгалантөр)-д даалгасугай.

3. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг үнэлгээний хороонд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

У.АЛТАНХҮҮ

